



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 09

Мандалговь

Хөрөнгө акталж,
данснаас хасах тухай

Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 2.1.7, 5.8.а дахь заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Дэрэн сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 13,675,000.00 /Арван гурван сая зургаан зуун далан таван мянган төгрөг/-ний анхны өртөгтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн 41-11 ДУА улсын дугаартай УАЗ-315122 маркын автомашиныг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.
2. Хөрөнгө худалдах үнийн доод хязгаарыг 1,500,000.00 /Нэг сая таван зуун мянган/ төгрөгөөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.
3. Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Дэрэн сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Ч.Уранбайгальд даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцоожид үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР

